

ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН 2025

Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, үйлчилгээг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд уламжлалт хэвлэл мэдээллийн суваг болох Телевиз, Сонин, Сайт, Радио-гоос гадна дижитал медиа буюу цахим платформ, цахим сувгуудаар дамжуулж нийгмийн даатгалын үйл ажиллагааны сурталчилгааг хийж байна. Өнөөдрийн байдлаар:

- www.ndaatgal.mn сайт
- Фэйсбүүк
- Инстаграмм
- “Youtube” суваг
- Хэвлэл мэдээллийн байгууллага гэсэн сувгуудаар нийгмийн даатгалын мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчилж байна.

Фэйсбүүк

Нийгмийн даатгалын байгууллагын пэйж хуудас болох @sigomongolia буюу Нийгмийн даатгалын ерөнхий газар хуудсаар 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйлчилгээг сурталчилсан рийл 42, стори рийл 8, постер мэдээлэл 370, цаг үеийн мэдээлэл 237, контент 16, 2D видео контент 2, 3D видео контент 2, лайв /шууд дамжуулалт/ 4, нийт 681 удаагийн мэдээлэл бэлтгэн **97.115** удаа түгээж, давхардсан тоогоор **25.191.552** /хандалтын тоо/ хүнд хүрсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын @sigomongolia сошиал хуудас нь **177.000** дагагчтай болсон бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дагагчийн тоо **28.000**-аар нэмэгдсэн байна.

Вебсайт

Нийгмийн даатгалын байгууллагын албан ёсны вэб сайт болох www.daatgal.mn сайтад 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт **9** төрлийн цэсэнд **727** төрлийн хууль, журам, мэдээллийг шинэчилэн оруулж, шинээр **49** видео мэдээ, **193** постер мэдээлэл, цаг үеийн мэдээ мэдээлэл **296**, **13** статистик мэдээг байршуулсан.

Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын нэгдсэн сайт болох emongolia.mn сайтад 9 дүгээр сараас хойш хөгжүүлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 7 төрлийн цэсэнд **98** төрлийн хууль, журам, цахим үйлчилгээ мэдээллийг шинээр оруулж, **11** статистик мэдээг байршуулсан.

Өмнө нь ашиглаж байсан Ndaatgal.Gov.mn цахим хуудас шинэчлэгдэж, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д нэгдсэн тул байгууллагын талаарх бүх мэдээллийг нэг бүрчлэн дахин шинээр оруулах хэрэгцээ шаардлага гарсан.

Хэвлэл мэдээлэл:

2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 12-р дугаар сарын Тайлант хугацаанд Zaag.mn, neguun.mn, zarig.mn, zindaa.mn, tovch.mn, shuud.mn, dorgio.mn, mass.mn, news.mn, gogo.mn, medee.mn, gerelmedia.mn, ulsturch.mn, ikon.mn, time.mn, eguur.mn, suvd.mn, mnb.mn, itoim.mn, Өглөөний сонин, Өнөөдөр сонин, Зууны мэдээ, Mongol HD, ТВ-8, Тэнгэр тв, TV-9, TV-5, Sbn, Star tv, Ulzii tv, UBS, ETV, NTV, MM Агентлаг, C1, Parliament, MN25, Eagle TV зэрэг **45** /давхардсан тоогоор/ хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан **470** /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажиллалаа.

АЙМАГ, ДҮҮРГИЙН ПЭЙЖ ХӨТЛӨЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ДҮГНЭЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын ҮХОНХГ нь 2025 оны 01 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл, 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн даатгалын байгууллагуудын Фэйсбүүк хуудсуудын үйл ажиллагааг сайжруулах зөвлөгөө , хяналтыг тогтмол зохион байгуулж, нийтэд нээлттэй мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажиллаа.

Өнгөрсөн хугацаанд:

- Фэйсбүүк хуудсын тохиргоо;
- Байгуулагын мэдээллийг хэрхэн оруулах;
- Постын тоо болон хандалтыг хэрхэн өсгөх;
- Фэйсбүүк хуудсын аюлгүй байдлын талаар зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг тасралтгүй гүйцэтгэж Фэйсбүүк хуудсыг стандартжуулан ажиллаж байна.

2025 оны 03 дугаар сараас өнөөдрийг хүртэл Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн даатгалын байгууллагуудын Фэйсбүүк хуудсуудын дагагч , пост, хандалтын тоо огцом өссөн дүнтэй байна.

Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон НДЕГ-ын постыг харьяа байгууллагууд шэйр хийж түгээх нь өссөн үзүүлттэй байна.

Пэйжийн нэр	Дагагчийн тоо		Постын дундаж тоо		Постын дундаж хандалт	
	2025/03	2025/11	2025/02	2025/11	2025/02	2025/11
Нийгмийн даатгалын ерөнхий газар	158,000	176,000	18	80	4,545	19,002
Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар	4,000	4,100	10	87	15	91
Баянгол дүүргийн Нийгмийн Даатгалын Газар	23,000	25,000	6	60	91	521
Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс	210	215	-	28	-	76
Баянзүрх Дүүргийн Нийгмийн Даатгалын Газар	27,000	30,000	9	30	243	930
Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар	3,100	3,700	5	80	32	748
Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газар	18,000	21,000	32	83	510	1,919
Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар	22,000	23,000	11	23	743	552
Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	23,000	3,000	13	128	200	655
Чингэлтэй Дүүргийн Нийгмийн даатгалын газар	14,000	15,000	12	61	642	2,610
Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар	4,900	5,600	24	66	324	767
Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын газар	1,800	3,800	9	25	107	504
Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын Газар	5,800	6,400	1	51	47	610
Булган Нийгмийн Даатгалын Газар	6,400	6,600	15	27	232	376
Говь-Алтай Нийгмийн Даатгалын газар	4,300	5,400	13	86	69	1,283
Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын газар	1,900	2,100	41	122	192	660
Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар	9,500	15,000	18	67	786	1,757
Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын газар	4,800	5,200	29	44	396	649
Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газар	9,400	10,000	21	39	1,259	887
Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газар	3,000	3,800	14	46	106	918
Завхан Аймгийн Нийгмийн даатгалын газар	3,500	4,100	12	66	264	275

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар	21,000	22,000	31	65	831	1,297
Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газар	2,700	6,500	27	71	720	4,504
Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газар	5,600	6,000	1	60	30	167
Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын газар	4,600	5,300	6	60	208	1,194
Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	2,100	971	1	14	15	221
Төв аймгийн Нийгмийн даатгалын газар	1,300	3,300	18	38	195	916
Увс Аймаг Нийгмийн Даатгалын газар	3,800	4,600	2	81	21	443
Ховд аймгийн нийгмийн даатгалын газар	5,600	6,600	9	34	85	705
Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар	6,300	6,500	16	85	3,197	551
Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар	2,300	3,500	20	30	379	869